



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/271

Номгон

Г "Эрүүл иргэн - Хонгорын баялаг" арга
хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй "Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөний үзэл баримтлалын хүрээнд зонхилон тохиолдох өвчнөөс урьдчилан сэргийлэх, иргэдэд эрүүл идэвхтэй амьдрах, зөв хооллох, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх, хорт зуршлаас татгалзах, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, илүүдэл жингүй эрүүл Баянхонгорчуудыг бий болгох зорилгоор арга хэмжээний төлөвлөгөө боловсруулахаар шийдвэрлэснийг тэмдэглэн Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 2.1, 2.2, 3.5, 8.1, 8.3 дахь заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1."Эрүүл иргэн-Хонгорын баялаг" арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Д.Энхжаргал Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

П.Отгонбаяр Төрийн захиргааны, удирдлагын хэлтсийн дарга

Д.Сарангарав Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

С.Байгалмаа Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Т.Хишигбаатар Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Л.Мандал Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

В.Эрдэнэчимэг Төрийн архивын тасгийн дарга

Г.Нэмэхбаяр Цэргийн штабын дарга, хурандаа

642310673

2.

Г.Энхбаяр	Баянхонгор сумын Засаг дарга
Б.Мөнхбаяр	Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн дэд хурандаа
Н.Энхжаргал	Эрүүл мэндийн газрын дарга
Ж.Алтанцэцэг	Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
У.Балжинням	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Б.Оюунбаатар	Биеийн тамир, спорт хорооны газрын дарга
Г.Пунцагдаш	"Жаргалтай амьдрал" сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төвийн дарга

Нарийн бичгийн дарга:

В.Наранчимэг

Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

2."Эрүүл иргэн-Хонгорын баялаг" арга хэмжээний төлөвлөгөөг иргэд, төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоотой боловсруулж, үр дүнтэй ажиллахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3.Уг захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН